

ШИНЭ НОМ

АРХЕОЛОГИЙН АЛТ ЭРДЭНЭСИЙН ДУРСГАЛ

Д.Наваан

“Археологийн алт эрдэнэсийн дурсгал” хэмээх энэхүү

бэсрэгхэн дэвтэрт олон мянганы түүх соёлын дурсгалтай Монгол орны газар шороонд хадгалагдан үлдсэн ховор нандин олдвороос аль үлэмж ховор, ганцын төдий хувьтай, зарим нь иж бүрэн цогцолбор, монголын эртний түүхийн янз бурийн цаг үед холбогдох зөвхөн үнэт металл алтаар үйлдсэн хэрэглэгдхүүнээс хамруулжээ. Эдгээр нь монголын эртний түүхэнд эзлэх байр суурьтай, бидний өвөг дээдсийн уран гар, хурц ухааны үнэлэхүй бодит гэрч төдийгүй, археологийн судалгаанд нэгээхэн дусал нэмэрлэж байгаа аж.

Зохиогч археологчийн зууны тал илүү хугацаанд эх орноо хөндлөн гулд хэрэн явж, илрүүлсэн

алтан олдворын сүүлчийнх – 2004 онд Сүхбаатар аймгийн Онгон сум, Таван толгойн XIII зууны холбогдолтой шинэ олдвороос уг номонд оролцуулсан болно.

